

ЭРДЭНЭ РЕСУРС ВАРРАНТЫН ХУГАЦААГ ГУРВАН САРААР СУНГАВ

Хэвлэлийн Мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот
2020.11.24

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") нь 2018 оны 6-р сард хаагдсан хаалттай санхүүжилтийн хүрээнд гаргасан 11,314,580 энгийн хувьцаа худалдан авах эрх бүхий варрант ("Варрант")-ын хугацааг сунгахаар болсныг мэдээлж байна. 2020 оны 12-р сарын 8-ны өдрөөс эхлэн эдгээр варрантын хүчинтэй хугацааг гурван сараар буюу 2021 оны 3 сарын 8-ны өдөр хүртэл сунгасан. Варрантыг хэрэгжүүлэх \$0.60-ын үнэ болон бусад нөхцөлүүд өөрчлөгдөхгүй.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өндөр агуулга бүхий алт, алт суурь металлын хэтийн төлөв бүхий талбайнуудыг нээн илрүүлснээс хөгжүүлэлт хийх боломжтой хэмээн Баян Хөндий, Алтан Нар ордуудыг тодорхойлсон. Компани нь 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com -оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ,

хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон захзээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419
И-мэйл: info@erdene.com
Twitter: <https://twitter.com/ErdeneRes>
Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>
LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>
YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>